



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2022/16-3-ШТА-ГА

Баянхонгор аймагт 2021 онд шинээр эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц шийдэгдэж, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн бодлого хэрэгжиж байна.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Б.Нарангэрэл
Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	5
<i>А.1. Баянхонгор аймагт 2021 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь улсын болон орон нутгийн урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.</i>	5
<i>А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалт зөрчигдөх байдал таслан зогсохгүй байна.</i>	7
<i>А.3. Төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг дунд хугацааны бодлоготой уялдуулаагүйгээс гүйцэтгэж буй ажлын ачаалал харилцан адилгүй байна.</i>	9
БҮЛЭГ Б. БАЯНХОНГОР АЙМАГТ 2021 ОНД ШИНЭЭР ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖСЭН БАЙНА.	12
<i>Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж байгаа ч төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлэхдээ холбогдох журмын заалтыг баримтлаагүй, эрх шилжүүлсэн шийдвэрийг тухай бүр ирүүлээгүй байна.</i>	12
<i>Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулаагүйгээс зарим ажлууд огт буюу хугацаандаа хэрэгжихгүй байна.</i>	16
<i>Б.3. ГХБХБГ нь Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс хяналт тавих гэрээг байгуулаагүй байна.</i>	20
<i>Б.4. 2021 онд хэрэгжиж байнгын ашиглалтад авсан 20,748.7 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.</i>	24
<i>Б.5. Баянхонгор аймагт 2021 онд шинээр эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц шийдэгдэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хадгалалт, арилжааг дэмжсэн бодлого хэрэгжиж байна.</i>	27
ДҮГНЭЛТ: 29	
ЗӨВЛӨМЖ:	30
ҮАГ-ыгн Аудитын гуравдугаар газарт хүргүүлэх санал.....	31

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ХБТХОТ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх; ➤ Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнтэй хийгдсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийв. Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 2021 онд эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 25,380.0 сая төгрөгийн өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг шинээр баталсан бөгөөд өмнөх оноос шилжиж ирсэн 39,358.3 сая төгрөгийн өртөгтэй 16 төсөл арга хэмжээ, нийт 64,738.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл арга хэмжээг хамруулав.
Аудитын хязгаарлалт	Аудитад 2021 онд Төсвийн тухай хууль болон аймгийн ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс бусад тайлант он болон эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээг хамааруулаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Нарангэрэл, гэрээт аудитор Д.Цэцэгмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2022 оны 03 дугаар сарын 28-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад дэд тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 04 дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Хүндрэл
бэрхшээл**

Байхгүй

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

А.1. Баянхонгор аймагт 2021 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь улсын болон орон нутгийн урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021 онд хөгжлийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт 2021 онд 64,738.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 27,283.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл, арга хэмжээ (цаашид ТАХ гэх) батлагдсаны 39,358.3 сая төгрөгийн 16 ТАХ нь өмнөх оноос шилжиж ирсэн хөрөнгө оруулалт байна.

Аудитаар 2021 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 25,380.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7,880.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 12 ТАХ-г төлөвлөхдөө урт, дунд богино хугацааны бодлоготой уялдсан байдалд авч үзэв. /Хавсралт № 01/

Баянхонгор аймагт 2021 онд хэрэгжихээр батлагдаж, аймгийн ТЕЗ-чид эрх шилжиж ирсэн 12 төсөл, арга хэмжээ нь “Алсын хараас 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна. Тухайлбал:

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “төлөвлөлт төвтэй хөгжил” зорилт дэвшүүлсэн бөгөөд зорилтын хүрээнд Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт сумдад “Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр” хэрэгжүүлэн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ байгуулах ажил хийгдэж байна.

Мөн Баянхонгор дагуул хот байгуулах, хотын төвлөрөл сааруулах зорилтын хүрээнд Баянхонгор аймгийн төвийн баруун урд хэсэгт “Шинэ суурьшлын бүс”-ийг шинээр төлөвлөж, өмнөх онуудад 640 хүүхдийн сургууль, 14 ортой эмнэлэг, хувийн аж ахуйн нэгжүүдэд газар олгож 9 давхар 2 орон сууц зэрэг бүтээн байгуулалтыг хийж байсан бол, 2021 онд “Цэвэр хот төсөл хэрэгжүүлэх” төсөл арга хэмжээний хүрээнд

1,000.0 сая төгрөгөөр инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЕЗ-ийн саналд үндэслэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулахаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Баянхонгор аймгийн Засаг дарга албан бичгээр холбогдох яаманд хүргүүлэн ажилласан байна. Тухайлбал:

- БОАЖС-д 2020 оны 1а/416 тоот
- МУ-ын Шадар сайдад 2020 оны 1а/417 тоот
- Эрчим хүчний сайдад 2020 оны 1а/418 тоот
- Барилга, хот байгуулалтын сайдад 2020 оны 1а/419 тоот
- Батлан хамгаалахын сайдад 2020 оны 1а/420 тоот
- Зам тээврийн хөгжлийн сайдад 2020 оны 1а/421 тоот
- ХХААХҮ-ийн сайдад 2020 оны 1а/422 тоот
- Соёлын сайдад 2020 оны 1а/423 тоот
- БШУ-ны сайдад 2020 оны 1а/424 тоот
- Эрүүл мэндийн сайдад 2020 оны 1а/425 тоот

албан бичгүүдээр хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг тус тус хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

Баянхонгор аймгийн Засаг дарга нь 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1а/425 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайдад 2021 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал хүргүүлэхдээ Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний 1,100.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 ТАХ-г жагсаалтад оруулсан байна.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээ нь төсөвт батлагдах боломжгүй эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэж байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г эрэмбэлэн ангилж, холбогдох яамдад хүргүүлэхдээ эрхлэх асуудлын хүрээнд жагсаалтыг зөв ангилж холбогдох яамдад хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Шинээр батлагдаж 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд аймгийн ТЕЗ-аас хүрүүлсэн саналын жагсаалтад тусгаагүй, 13,030.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ байна.

Харин БОАЖЯ-наас эрх шилжиж ирсэн арга хэмжээг аймгийн ТЕЗ-аар дамжуулаагүй аймгийн Байгаль орчны газраас хэрэгцээ шаардлагыг тодорхойлж харьяа яаманд хүргүүлсэн байна.

Хүснэгт № 1. Баянхонгор аймгийн ТЭЗ-чаар дамжаагүй хөрөнгө оруулалт

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн
			Эхлэх	Дуусах		
1	XVII.1.12	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	2021	2023	12,000.0	1,500.0
2	XVII.3.12	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/	2021	2021	900.0	900.0
3	БОАЖЯ/ 202103046	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	2021	2021	100.0	100.0
4	БОАЖЯ/ 202103058	Баянхонгор аймгийн Цагаан агуй орчмын аялал жуулчлалыг жимийг тохижуулах	2021	2021	30.0	30.0
		Дүн			13,030.0	2,530.0

А.1.3. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлж холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ХБХОТХ -т 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулахаар 223,394.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 155 төсөл арга хэмжээний санал ирснийг тухайн төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, ТЭЗҮ, зураг төсөв үндэслэл зэргийг эрэмбэлж саналыг холбогдох яамдад хүргүүлснээс 25,380.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээнд 7,880.0 сая төгрөг батлагдсан байна.

А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалт зөрчигдөх байдал таслан зогсохгүй байна.

А.2.1. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгавар, бусад шаардлагатай бичиг баримтыг үндэслэж боловсруулсан байна.

Аймгийн хэмжээнд УТХО-аар 2021 онд шинээр хэрэгжих 12 төсөл, арга хэмжээ батлагдаж үүнээс зураг төсөв шаардлагатай 4 төсөл арга хэмжээ байгаагаас Эрдэнэцогт, Галуут сумдад хэрэгжиж буй “Сумын төвийн шинэчлэл” хөтөлбөр нь “Түлхүүр гардуулах” гэрээний нөхцөлтэй, “Цэвэр хот” төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх 1,000.0 сая төгрөгийн, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах” ажлын 6 багцын 12,000.0 сая төгрөгийн ажлаас 4 багцын ажилд

зураг төсөв хийгдсэн байна. Үүнээс Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх ажил, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл арга хэмжээний Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх-Багц 4 ажлын төсөв нь Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын 27,032.9 сая төгрөгийн төсөвт тусгагдсан , Багц1: ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил, багц 2: Ногоон тэжээлийн үйлдвэр, Багц 3: мах, хүнсний ногооны 1000 тн агуулахын барилгын ажлуудад тус бүрд нь зураг төсөв зохиож, магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.

Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг Баянхонгор аймгийн Ерөнхий архитектор боловсруулан баталж зураг төсөл зохиогчид хүргүүлсэн байна. Ажлын даалгаврыг орон нутгийн хэрэгцээ шаардлага, инженер геологийн дүгнэлт, бусад холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэргийг үндэслэн боловсруулсан ба зураг төсөл зохиогч нь ажлын даалгаврын дагуу ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Дээрх ажлуудын зураг төсвийг “Инж байгууламж “ , “Проектсити”, “Мандала арт констракшн” ХХК-уудтай гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд зураг төслийг магадлал хийлгэж , дүгнэлт гаргуулан захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

А.2.2. Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд боловсруулж, баталгаажуулсан байна.

Дээрх шинээр хэрэгжүүлсэн зураг төсвийг гэрээгээр гүйцэтгэсэн “Инж байгууламж” ХХК нь ЗТ11-1628/17 дугаартай, “Проектсити” ХХК ” нь ЗТ18-11-11/17 дугаартай, “Мандала арт констракшн” ХХК нь ЗТ44-391/21 дугаар бүхий тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага боловсруулж, баталгаажуулсан байна.

А.2.3. Барилга, байгууламжийн зураг төслийн зардлыг БХБС-ын 2020.6.14-ний 108 тоот тушаалаар баталсан барилгын зураг төсөв зохиох жишиг үнийг үндэслэсэн эсэхийг нотлох баримт тооцоолол байхгүй байна.

Барилга, байгууламжийн зураг төслийн зардлыг БХБС-ын 2020.6.14-ний 108 тоот тушаалаар баталсан Барилгын зураг төсөв зохиох жишиг үнийг үндэслэсэн эсэхэд тооцоо судалгаа байхгүй байна.

Зураг төсөл зохиогч нь Багц1: ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил, багц 2: Ногоон тэжээлийн үйлдвэр, Багц 3: мах, хүнсний ногооны 1000 тн агуулахын

барилгын ажил, Оготнотой булгийн тохижилтын ажил гэсэн 4 төсөл арга хэмжээний зураг төслийн ажлыг 210,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба энэ нь ажил тус бүрээр үзэхэд нийт төсөвт өртөгт 1,6%-ийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн ажил хариуцсан мэргэжилтэн ажлын зураг, төсөв хийлгэх ажлын хөлсийг жишиг нормын дагуу тооцдоггүй нь БХБС-ын 2020.6.14-ний 108 тоот тушаалаар баталсан Барилгын зураг төсөв зохиох жишиг үнийг баримтлаагүй байна..

Иймд төсөл, арга хэмжээний зураг төслийг хийлгэхдээ БХБС-ын 2020.6.14-ний 108 тоот тушаалаар баталсан Барилгын зураг төсөв зохиох жишиг үнийг баримтлан зураг төслийн гэрээг хийж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.2.4. Барилга байгууламжийн зураг төслийг магадлалаар баталгаажуулсан байна.

Барилга хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв нь “Инж байгууламж” ХХК-ийн боловсруулсан Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын 27032,9 сая төгрөгийн төсвийг 2021.01.10-ний өдрийн 127/2021 дүгнэлтээр, “Проексисти” ХХК ”-ийн гүйцэтгэсэн 4,104.3 сая төгрөгийн төсөвтэй Ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажлын төсвийг 2021.09.02-ний 1433/2021 тоот дүгнэлтээр, “Мандала арт констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн 4,869.2 сая төгрөгийн төсөвтэй мах, хүнсний ногооны 1000 тн агуулахын барилгын ажил, 2,570.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон тэжээлийн үйлдвэрийн ажлын төсвийг 2021.08.24-ний 1242/2021 тоот дүгнэлтээр тус тус баталгаажуулсан байна.

А.2.5. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан эсэхийг мэргэжлийн шинжээч оролцуулаагүй тул нотлох боломжгүй байна.

А.3. Төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг дунд хугацааны бодлоготой уялдуулаагүйгээс гүйцэтгэж буй ажлын ачаалал харилцан адилгүй байна.

А.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг анхан шатны нэгжээс авч эрэмбэлж хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон санал бүрийг холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Гэвч зарим төсөл арга хэмжээ нь ТЕЗ-чийн хүргүүлсэн санал, магадлал хийгдсэн зураг төсөвт тусгагдсан хүчин чадлаас бага хэмжээтэй батлагдсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

Баянхонгор аймгийн Баянхонгор сумд баригдаж буй Номгон ахлах сургуулийн барилгын ажлыг ТЕЗ-чаас 440 хүүхдээр тооцож, зураг, төслийг магадлалаар баталгаажуулсан байхад 2021 оны төсөвт 320 хүүхдийн хүүхдийн хүчин чадалтай төсөл арга хэмжээгээр батлагдсан байна.

Иймд ТЕЗ-аас ирүүлсэн хүчин чадлыг харгалзан үзэж, тооцоолсон зураг төслийг үндэслэн хүчин чадлыг тодорхойлж байх зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх саналыг УАГ-ын АГГ-т хүргүүлэв.

А.3.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж байгаа нь аймаг орон нутгаас хамаарахгүй байна. Тухайлбал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт эрх шилжин хийгдэж буй төсөл, арга хэмжээг анхан шатны нэгжээс санал авч эрэмбэлэн жагсаалтыг хүргэх ажил хийгдсэн боловч, хүргүүлсэн саналд тусгагдсан зураг төсөв шаардлагатай ажлын хувьд төсөв батлагдсанаас хойш зураг төсөв хийлгэж магадлалаар баталгаажуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.4¹ дэх заалтыг зөрсөн байна.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн холбогдох мэргэжилтнээс тодруулахад “Бидний санал өгсөн төсөл, арга хэмжээнээс өөр төсөл арга хэмжээний хувьд бидэнд зураг, төсөв байдаггүй, бид нөхөж зураг төсөв хийлгэх, магадлалаар баталгаажуулах хугацааг хүлээх боломжгүйгээр ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу яаралтай худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг. Нэгэнт аймаг орон нутагт шийдвэрлэгдсэн хөрөнгө оруулалтыг буцаан татуулахгүйн тулд хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна” гэсэн тайлбар өгөв.

А.3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг харилцан адилгүй баталснаас шалтгаалж, батлагдсан санхүүжилтийг авах зорилгоор илүү гүйцэтгэл гаргах, дутуу санхүүжилтийг орхигдуулснаас ажил удаашрах шалтгаан болж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 15 төсөл арга хэмжээний санхүүжих дүн 1.5-96.8 хувийн санхүүжилт батлагдсан байна.

Хүснэгт № 2 Төсвийн тухай хуульд туссан төсөл, арга хэмжээний санхүүжих дүн

Хамрах он	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжих хувь /Нийт ТАХ-ний дундаж хувь/
2018	1	3,339.0	50.0	1.5

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

2019	6	10,195.8	194.0	32.3
2020	9	12,111.0	9,157.8	73.9
2021	12	25,380.0	7,880.0	81.0

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнө онд батлагдсан ТАХ-ний хувьд 2021 онд дунджаар 73.9 хувийг төлөвлөснөөс барилга угсралтын ажил хугацаандаа бүрэн хэрэгжихгүй, дахин он дамжих нөхцөл үүсэж байна. Тухайлбал:

- Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн барилгын ажил 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил 2020 онд батлагдахдаа санхүүжих дүнг 300.0 сая төгрөгөөр буюу 25 хувиар баталсан байхад 2021 онд 900.0 сая төгрөгөөр буюу 75 хувиар баталснаас 2021 онд ажил бүрэн хийгдээгүй
- Усан бассейн, спорт цогцолборын барилгын ажил 9,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын санхүүжих дүнг батлахдаа 2019, 2020 онд 22.1 хувь буюу тус бүр 2,000.0 сая төгрөг, 2021 онд батлагдахдаа 5,000.0 сая төгрөгөөр буюу 55.6 хувиар баталсан
- Баянцагаан сумын 320 суудалтай сургуулийн 4,383.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажил санхүүжих дүнг батлахдаа 2019 онд 18,5 хувь буюу 800.0 сая, 2020 онд 14.4 хувь буюу 632.9 сая, 2021 онд 67,3 хувь буюу 2,950.1 сая төгрөгөөр баталсан
- Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 1,200.0 сая төгрөгийн барилгын ажлын санхүүжих дүнг батлахдаа 31.0 хувь буюу 372.2 сая, 2021 онд 69 хувь буюу 827.8 сая төгрөгөөр баталсан.

Дээрх төсөл арга хэмжээнүүд болон зарим бусад төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд жигд бус хуваарилж, өмнөх оноос шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын үр дүнг гаргаагүй байхад дараа, дараагийн шинэ хөрөнгө оруулалт нэмж баталж санхүүжих дүнд ачаалал үүсгэж байна.

Хөрөнгө оруулалтын үлдэгдэл дутуу ажлын санхүүжилтийг аймгийн Техник хяналтын барьцаа дансанд байршуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжих дүнг төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд тэнцвэртэй хуваарилаагүйгээс Төсвийн тухай хуульд заасан хугацаанд гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх боломж алдагдаж байна.

Иймд төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг дунд хугацааны хөтөлбөр хуваарийн дагуу жигд тасралтгүй хуваарилан хуульд өргөн мэдүүлж байх зөвлөмжийг холбогдох эрх бүхий яамдад зөвлөмжөөр хүргүүлэх саналыг УАГ-ыг АГГ-т хүргүүлэв.

А.3.4. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн тах-ний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Баянхонгор аймагт 2021 онд өмнөх оноос дамжин хэрэгжсэн 39,358.3 сая төгрөгийн 16 ТАХ, тайлант онд шинээр батлагдаж хэрэгжиж байгаа 25,380.0 сая төгрөгийн 12 ТАХ-ний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ батлуулаагүй байна.

БҮЛЭГ Б. БАЯНХОНГОР АЙМАГТ 2021 ОНД ШИНЭЭР ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖСЭН БАЙНА.

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж байгаа ч төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлэхдээ холбогдох журмын заалтыг баримтлаагүй, эрх шилжүүлсэн шийдвэрийг тухай бүр ирүүлээгүй байна.

Б.1.1. УТХО-аар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлэхдээ тез нар журамд заасан хугацааг баримтлахгүй байна.

Тайлант онд БШУЯ, БХБЯ, ХХААХҮЯ, ЭМЯ, БОАЖЯ-ны сайдын багцад УТХО-ын эх үүсвэрээр хэрэгжүүлэх нийт 25,380.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах захиалагчийн эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Аудитаар дээрх 12 төсөл арга хэмжээний Төсвийн ерөнхийлөн захирагчийн захиалагчийн эрх шилжүүлсэн шийдвэрүүдтэй танилцахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 3 Төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн судалгаа

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг / сая төгрөг/	ТЕЗ-ийн нэр	ТЕЗ-ийн шийдвэрийн		ТЕЗ-ийн шийдвэрийг ирүүлсэн		Хэтэрсэн хоног	
				Огноо	Тушаа-лын дугаар	Огноо	Албан бичгийн дугаар	Хуулийн хугацаанаас	Шийдвэр ирүүлсэн
1	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	5,000.0	БХБС	2021/2/10	34	2021/3/04	1/799	18	34
2	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	5,000.0	БХБС	2021/2/10	34	2021/3/04	1/799	18	34
3	Цэвэр хот төсөл хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум/	1,000.0	БХБС	2021/2/10	34	2021/3/04	1/799	18	34
4	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	12,000.0	ХХААХҮС	2021/2/10	А-33	2021/3/09	01/729	18	34
5	Жижиг, дунд, бичил үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр /Баянхонгор, Баянхонгор сум/	300.0	ХХААХҮС	2021/2/10	А-33	2021/3/09	01/729	18	34
	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх								

6	угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/	900.0	ХХААХҮС	2021/2/10	A-33	2021/3/09	01/729	18	34
7	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Баянхонгор, Баянхонгор, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Баянлиг, Жинст, Заг сум/	800.0	ЭМС	2021/2/25	A/81	2021/3/05	1a/1000	33	43
8	Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн барилгын дээврийн их засвар	70.0	ЭМС	2021/7/19	A/472	2021/7/22	2/3859	177	180
9	Баянхонгор аймгийн Цагаан агуй орчмын аялал жуулчлалыг жимийг тохижуулах	30.0	БОАЖС	2021/1/29	A/34				
10	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын цэцэрлэгийн барилгын их засвар	80.0	БШУС	2021/1/18	A/13	2021/3/02	2/945	0	14
11	Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын цэцэрлэгийн дээврийн их засвар	100.0	БШУС	2021/1/18	A/13	2021/3/02	2/945	0	14
12	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	100.0	БОАЖС	2021/1/29	A/34				
	ДҮН	25,380.0							

Судалгаанаас үзэхэд ТЕЗ нар УТХО-аар хэрэгжих төсөл арга, хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 363 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.11. “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэснийг мөрдөөгүй, зарим ТЕЗ-ийн эрх шилжүүлсэн шийдвэр журамд заасан хугацаанд гарсан боловч шийдвэрийг аймгийн ТЕЗ-д хүргүүлэх явц удаашралтай байгаа нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй болох эрсдэлтэй байна. Тухайлбал:

- ХХААХҮС-ын болон БХБС-ын багцаас УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр нь журамд заасан хугацаанаас 18 хоногийн, шийдвэрийг ирүүлэхдээ 34 хоногийн дараа

- ЭМС-ын багцаас УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр нь журамд заасан хугацаанаас 33-177 хоногийн, шийдвэрийг ирүүлэхдээ 43-180 хоногийн дараа

-БШУС-ын багцаас УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр нь журамд заасан хугацаанд гарсан боловч шийдвэрийг ирүүлэхдээ 14 хоногийн дараа тус тус ирүүлсэн байна.

Иймд улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ хуульд заасан хугацаанд шийдвэрийг гаргаж, хугацаа алдахгүй эрх шилжүүлж буй ТЕЗ-чид хүргүүлж байх зөвлөмжийг холбогдох эрх бүхий газарт хүргүүлэх саналыг ҮАГ-ын АГГ-т хүргүүлэв.

Б.1.2. УТХО-аар хэрэгжих төсөл арга, хэмжээний тендерийг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан байна. Төлөвлөгөөнд тусгагдсанаар Баянхонгор аймагт 2021 онд УТХО-аар хэрэгжих нийт 12 төсөл арга хэмжээний 25,380.0 сая төгрөгийн захиалагчийн эрх шилжиж ирснээс 25,200.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 180.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар зохион байгуулжээ.

Төлөвлөгөөгөөр дээрхи 12 төсөл арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021.04.10-ны дотор, 2 төсөл, арга хэмжээг 2021.04.29-ний дотор зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон байх, 1 төсөл арга хэмжээний захиалагчийн эрх шилжүүлсэн шийдвэр нь 2021.07.19-нд ирсэнтэй холбоотой 2021.08.20-ны дотор худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлийг судалж үзэхэд гэрээ байгуулах эрх олгосон хугацаа нь төлөвлөснөөс 14-120 хоногийн дараа хэрэгжсэн байна.

Энэ нь Монгол улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой зарим тендерийн нээх хугацааг сунгасан, зарим тендерт оролцогчийн санал ирээгүй болон ирүүлсэн санал шаардлага хангахгүйгээс дахин зарласан нь дээрх хугацаанд нөлөөлжээ.

Тендерийг зарласнаас хойш тендерийг нээх, гэрээ байгуулахад хууль журамд заасан хугацааг мөрдөж ажилласан бөгөөд, үнэлгээний хороо байгуулсан тохиолдолд худалдан авах ажиллагаанд хугацаа алдаагүй байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу жишиг баримт бичгийг үндэслэн, ХБТХОХ-ээс ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан байна.

Тайлант онд УТХО-аар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан байна. Үнэлгээний хороонд давхардсан тоогоор нийт 64 хүн томилогдсоноос 2 ажлын тендер зарлах болон тендерийг үнэлэх явц 80 хувийн бүрэлдэхүүнтэй, бусад нь гишүүд бүрэн оролцсон байна. Үнэлгээний хорооны гишүүд нь бүгд худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай ба журмын дагуу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг бөглөж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Аудитын илрүүлэлт

-Гурванбулаг сумын Цэцэрлэгийн барилгын их засварын ажлын үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба үнэлгээний хорооны гишүүнээр томилсон 1 хүний АЗ сертификатын хугацаа дууссан байсан тул бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан гэх боловч шийдвэр нь байхгүй байна.

-Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөв арга хэмжээний багц :6 дахь Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх 1210.5 сая төгрөгийн ажлын зураг төсөв байхгүй, багц :3 дахь ажлын бүрэлдэхүүнд багтсан 523,6 сая төгрөгийн “бойны газар”-ын зураг ажил зэрэг нийт 1734,1 сая төгрөгийн батлагдсан зураг төсөвгүй ажилд тендер зарласан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.

Цаашид батлагдсан зураг, төсөв байхгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг байдлыг зогсоох зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн ерөнхий шаардлагыг тавьж, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүргүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан байна.

Төсөв нэмэгдсэн төсөл арга хэмжээг тендерийн хэмнэлтээс санхүүжүүлж буй ажлын нэмэгдсэн төсөв нь нийт төсөвт өртгийн 15 хувиас хэтрээгүй тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар 2021 онд ашиглалтад хүлээн авсан 4 төсөл, арга хэмжээнд 424.3 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны бүх үйл явцыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Тендерийг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг www.tender.gov.mn цахим сайтаар нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант онд аймгийн орон нутгат эрх шилжиж ирсэн 25,380.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж,тендерт шалгарсан оролцогч нартай 22,847.6 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан нь төсөвт 238.3 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцөл бүрдсэн байна.

Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь төлөвлөж, тайлагнасан ба шилэн дансны мэдээллийн сайтад холбогдох мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар гарган бичмэл тайланг хагас жилээр, жилийн эцсийн тайланг Сангийн сайдын 2021.6.30-ны 102 дугаар тушаалаар баталсан. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу батлагдсан маягтаар гарган баталгаажуулж Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-чийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар гарган 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан бөгөөд тайлант хугацаанд ЭМС, БШУС, БОАЖС-ын багцад батлагдан эрх шилжиж ирсэн 380,0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг нэмж 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр буюу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулжээ.

Худалдан авах ажиллагааны тайлан, үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүр “tender.gov.mn” сайтад байршуулсан байна.

Шилэн дансны нэгдсэн мэдээллийн сайтад тайлант жилийн аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авах ажиллагааны тайлан, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байна.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах ажлыг зохион байгуулаагүйгээс зарим ажлууд огт буюу хугацаандаа хэрэгжихгүй байна.

Б.2.1. Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд өмнөх оноос шилжсэн 19,403.6 сая төгрөгийн санхүүжих төсөвтэй 16 төсөл арга хэмжээ, шинээр эхэлсэн 7,880.0 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ, нийт 28.783.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Тайлант оны эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 12 төсөл арга хэмжээнээс 3 нь дараа онд шилжиж байгаа ба хуулийн дагуу 2021 онд дуусах 8 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй, 1 төсөл арга хэмжээ гэрээний сунгалт хийсэн байна.

Аудитын илрүүлэлт

Баян-Өндөр сумын Цэцэрлэгийн барилгын дээврийн их засварын ажлын гүйцэтгэгчээр "Гялгар хайрхан" ХХК шалгарч тус ажлыг 98,3 сая төгрөгөөр гүйцэтгэн 2021.08.25-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгөхөөр 2021.06.14-ний өдөр захиалагчтай 2021/137 тоот гэрээ байгуулсан боловч 2021.08.25-ны өдрийн НЭ 2021/137 тоот их засварын ажлын хугацаа сунгалтын гэрээгээр Цар тахлын улмаас барилгын ажил хугацаандаа дуусах боломжгүй байгаагаас 2021.11.10-ны өдрийг хүртэл хугацааг сунгасан атал ажил хийгдээгүй байна.

Өмнөх оноос шилжиж 16 төсөл арга хэмжээ 2021 онд ашиглалтад орохоор төлөвлөгдсөн хуульд хэрэгжиж дуусахаар бүрэн санхүүжилт нь батлагдсан 6 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй байна. / Хавсралт судалгаа 3/

Аудитын илрүүлэлт

- Баянцагаан сумын 320 хүүхдийн суудалтай Сургуулийн барилгын гүйцэтгэгчээр шалгарсан "Навтгар хайрхан" ХХК ажлыг төсөвт өртөг 4214,4 сая төгрөгт
- Усан бассейн, спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/-ийн гүйцэтгэгчээр "RMB" ХХК, гэрээний дүн 8,730.6 сая төгрөг
- Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/ барилга гүйцэтгэгчээр "Ган мөнхжин" ХХК, гэрээний дүн 1,669.6 сая
- Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ ажлын гүйцэтгэгчээр "Стандарт тоосго" ХХК, гэрээний дүн 944.3 сая төгрөг
- Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/-ажлын гүйцэтгэгчээр "Энхбаялаг констракшн" ХХК, гэрээний үнийн дүн 1,519.2 сая төгрөг
- Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/ ажлын гүйцэтгэгчээр "Зургаан даваа" ХХК, гэрээний үнийн дүн 1,168.1 сая төгрөг

Дээрх аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээнд заасны дагуу дутуу ажлыг гүйцэтгүүлж, хугацаанд үүргээ биелүүлээгүй зөрчилд гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх 995.0 сая төгрөгийн тендерт шалгарсан "Базардарь" ХХК -тай гэрээ байгуулахдаа ажлын гэрээ байгуулсан, тус компани нь тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод зааснаас өөр нэр төрлийн материалыг нийлүүлсэн байхад аймгийн Засаг даргын 2021.07.23-ний А/495 дугаар тушаалаар томилогдсон комиссын

2021/114 тоот актаар хүлээн авч, санхүүжилтийн 696.5 сая төгрөгийг олгосон, үлдэгдэл санхүүжилтийн 298.5 сая төгрөгийг олгохдоо ажил гүйцэтгэснээр гүйцэтгэл гаргаж баримт бүрдүүлсэн. Материал хүлээлгэн өгсөн сүүлийн гүйцэтгэлийг архивын баримтад үдэлгүй орхигдуулсныг аудитын явцад залруулсан.

Б.2.2. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын зүгээс үе шатны ажлын хяналтыг хэрэгжүүлж, хяналтаар илэрсэн зөрчлийг хэрэгжүүлсэн талаарх тайланг гүйцэтгэгч тухай бүр гаргаж ирүүлсэн боловч зөрчил дутагдал давтан гарсаар байгаа нь хяналт үр дүнтэй бүрэн хэрэгжээгүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2021 оны байдлаар эрх шилжсэн болон эрх шилжээгүй нийт 64,738.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59,445.6 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 28 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тайлангаас харахад ГХБХБ газар нь 2021 онд эрх шилжсэн болон эрх шилжээгүй хэрэгжүүлсэн нийт 24 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, хяналтаар илэрч буй зөрчил, дутагдлыг арилгах үүрэг даалгаврыг тухай бүр өгч ажилласан байна.

Зохиогчийн хяналтыг захиалагчтай хийсэн гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт дуусаж хүлээн авсан барилгын хувьд зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж захиалагчид ирүүлдэг бөгөөд, хэрэгжиж дуусаагүй барилгын хувьд хяналтын тайланг явцын дундуур зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, тайланг үндэслэн зохиогчийн хяналтын зардлыг тухай бүр олгож ирсэн байна.

Захиалагч, зохиогчийн зүгээс барилга угсралтын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэн гарсан зөрчлүүдийг тухай бүрд нь засаж, залруулж байгаа боловч 2021 онд ашиглалтад орсон барилгын чанар байдалд ашиглагч байгууллагаас ирүүлсэн санал гомдлоос харахад барилгын зарим ажил дутуу, дээврээс дусаал гоождог нийтлэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Аудитын илрүүлэлт

- 2020 оноос дамжиж хэрэгжсэн 453.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Баян-Өндөр сумын Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг "Бридж констракшн" ХХК гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч ашиглалтын чанар байдлыг газар дээр нь шалгах явцад чанарын шаардлага хангаагүй хийгдсэн 1 ангийн шалны хулдаасыг солихоор

гүйцэтгэгч компанитай тохиролцсон боловч солиогүй, хана зарим хэсгүүдэд цууралт үүссэн, үүдний хэсгийн талбайн явган замын хавтангууд хөдөлгөөн ихтэй, ХБИ-ний пандус зам шаардлага хангахгүй, цонхны дотор талын хана даган дээврээс ус гоожиж байгаа, шинэ хуучин 2 барилгын хүзүүвч хэсэгт ус зайлуулах хоолой байхгүйгээс ус тогтдог.

- Баянбулаг сумын 2019 оноос дамжиж хэрэгжсэн 1,842.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 160 хүүхдийн сургуулийн барилгыг “Шинэ өлгийн зам” ХХК нь гүйцэтгэж улсын комиссоор хүлээлгэн өгсөн бөгөөд ашиглалтын явцад 4 ангийн цонх хагарсан, номын сангийн хана болон зарим ангиудын хананд өнгөний шохой, будаг хагарч хуурсан, Дусаал гоожсон таазны замаскийг хийгдээгүй, гадна талбайн камер ажиллахгүй байдалтай байна.

- Баянхонгор сумын 2,7,9 дүгээр багийн 4,995.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 640 хүүхдийн сургуулийн барилгыг “Хөх бүрдний эх” ХХК гүйцэтгэж улсын комиссоор хүлээлгэн өгсөн бөгөөд ашиглах явцад Дээврийн залгаасаар дусаал дусдаг, Усны нөөцийн савны хананд цууралт үүссэн, цонх болон шилэн хананы хэсгүүдээр дулаан алдалт ихтэй, хананы зарим хэсэгт өнгөний цууралт өгсөн.

- Баянхонгор сумын “Номгон” ахлах сургуулийн барилга нь ашиглалтын явцад ханын өнгөн хэсгийн шаварт хагаралт үүссэн, залны үүдэн хэсэгт гипсэн хавтангаар хийсэн нь цөмөрч эвдрэл үүсэж байгаа, ангиудын гар угаалтуураас цөмөрч эвдрэл үүссэн, шээлтүүрийн арын хананд ус нэвчсэн, ханын доод хэсгээр хийсэн плита унаж, хагарч байгаа, суултуурыг нааж бэхлээгүй, буланд хийсэн тор ил гарсан.

Иймд дээрх чанаргүй хийсэн ажлыг гүйцэтгэгчээр дахин засварлуулах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т өгөв.

Б.2.3. УТХО-аар 2021 онд аймаг болон 7 суманд 800,0 сая төгрөгийн эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэхээр төсөв батлагдсан ба тендерийг 3 багцаар зарлаж шалгарсан компаниуд 747,0 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулж, тендерийн баримт бичигт тусгасан үзүүлэлт, хэмжээгээр бүрэн нийлүүлсэн байна.

Нийлүүлсэн хөрөнгийг ашиглагч байгууллагууд хүлээн авч хөрөнгөнд орлогод авч бүртгэсэн боловч зарим тоног төхөөрөмжийг ажиллуулах мэргэжлийн ажилтан дутмагаас бүрэн ашиглаагүй, ЭМГ-аас нэгдсэн журмаар мэргэжлийн байгууллагатай хамтарч сургалт авахаар төлөвлөсөн гэсэн тайлбарыг сумдын ЭМТ-ийн удирдлагуудтай ярилцлага хийх явцад өгч байсан.

Мөн зарим багаж хэрэгсэл тухайлбал эмнэлгийн түргэн тусламжийн машинд суурилуулах зориулалттай өвчтөн тээвэрлэх ор нь машинд суурилуулахад тохиромж муутай, хэт овор хэмжээ ихтэйн улмаас байнгын зориулалтаар нь ашиглахад хүндрэлтэй талаар зарим ашиглагч байгууллагын зүгээс санал тайлбар өгч байсан.

Аудитаар дээрх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хэрэглэгчид хуваарийн дагуу бүрэн олгосон эсэхийг шалгахад зарим тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн өгөөгүй, өөр газарт хуваарилсан зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт

- Аудитаар сумын ЭМТ –д нийлүүлэгдэх 2.1 сая төгрөгийн Gmobile интернэт холбох төхөөрөмж хуваарьт байгууллагадаа нийлүүлэгдээгүй байна.

Б.2.4. Өмнөх онуудад хэрэгжсэн ТАХ-ээс Бууцагаан сумын бага сургуулийн барилга, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2 км авто замын үлдэгдэл 800 метр замын ажил хийгдээгүй орхигдсон (2022 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа) байна.

Б.2.5. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ-ийг холбогдох хууль, барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж 2021 онд хэрэгжүүлсэн, 2022 онд хэрэгжүүлэх барилга байгууламж ТАХ байхгүй байна.

Б.3. ГХБХБГ нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс хяналт тавих гэрээг байгуулаагүй байна.

Б.3.1. Аймгийн ГХБХБГ нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс хяналт тавих гэрээг байгуулаагүй байна.

УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБ газар хэрэгжүүлэх үүрэгтэй боловч аймгийн ТЕЗ –тай гэрээг байгуулаагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

Аудитын илрүүлэлт

Монгол улсын Засгийн газрын 2017.06.14-ны “Дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоолд 2018 оны 316 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтөөр дүрмийн 3 дугаар зүйлийн 3.12. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын чиг үүрэг бүхий мэргэжлийн лаборатори бүхий агентлагтай гэрээ байгуулж, түүнд хяналт тавиагүй, аймгийн хөгжлийн бодлого барих бодлогын хэлтэс нь өдөр тутмын хяналт хэрэгжүүлж хяналтын тогтолцоог гажуудуулж байна.

Иймд Засгийн газрын 2017.06.14-ны “Дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоолд 2018 оны 316 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтөөр дүрмийн 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтыг хэрэгжүүлж, ажил хариуцсан агентлагтай гэрээ байгуулж ажиллах шаардлагатай байна.

Зохиогчийн хяналтыг захиалагчтай хийсэн гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт дуусаж хүлээн авсан барилгын хувьд

зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж захиалагчид ирүүлдэг бөгөөд, хэрэгжиж дуусаагүй барилгын хувьд хяналтын тайланг явцын дундуур зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж, тайланг үндэслэн зохиогчийн хяналтын зардлыг тухай бүр олгосон байна.

Б.3.2. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргаж ирүүлсэн тухай бүр системийн дээд байгууллагаас хянаж баталгаажуулж, санхүүжилтийн эрхийг нээж байна.

УТХО-аар 2021 онд хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтэд нийт 25,555.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээгдсэн байна.

Хүснэгт 4 :ТЭЗ-аас санхүүжилтийн эрх нээсэн байдал

ТЭЗ-ын нэр	Мөнгөн дүн (сая. төг)
Байгаль орчин, аялал жуулчлалын хөрөнгө оруулалт	130.0
БХБ-ын салбарын ХО	3,988.9
Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар	10,581.5
Засгийн газрын хэрэг эрхлэх газар ХО	827.8
Соёлын салбарын хөрөнгө оруулалт, их засвар	682.0
Спортын салбарын ХО	5,000.0
ХХААХҮ-ийн салбарын ХО	2,660.3
Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засвар	1,684.5
Нийт дүн	25,555.0

Төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагууд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналын журамд заасны дагуу батлагдсан маягтаар гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг гарган захиалагчаар хянуулж санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт № 5 Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний үнийн дүн	Нийт санхүүжилт	сая төгрөг
					2021 онд олгосон санхүүжилт
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баацагаан сум/	Бианконэро констракшн ХХК	1,200.0	1,200.0	827.8
2	Цэцэрлэгийн барилга, 280 ор / Баянхонгор сум/	Гал хонгор ХХК	3,339.0	2030.0	50.0
3	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/-"Шинэ өлгийн зам "	Шинэ Өлгийн Зам	1,842.4	1,828.2	106.3
4	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/-"Навтгар хайрхан" ХХК	Навтгар хайрхан ХХК	4,214.4	2,652.2	1,219.4
5	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, 2,7,9-р баг/	Хөх бүрдний эх ХХК	5,166.0	4,938.9	274.4
6	Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	Стандарт тоосго ХХК	944.3	547.8	247.8
7	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	Гурван булаг Сод ХХК	1,537.0	928.9	928.9
8	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/-	Энхбаялаг констракшн	1,519.2	1,322.3	822.3

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

9	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/- Эх бүрдэн ХХК	Эх бүрдэн ХХК	3,101.4	3,100.8	2,600.8
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/-"Зүүн шанд" ХХК	"Зүүн шанд" ХХК	1,589.8	1,569.8	1,069.3
11	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Баян-Өндөр сум/-"Бридж констракшн" ХХК	Бридж констракшн" ХХК	453.6	453.6	253.6
12	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/-	Зургаан даваа ХХК	1,168.0	1,058.3	868.0
13	Усан бассейн, спорт цогцолборын барилга	RMB ХХК	8,730.5	7118.4	3,118.4
14	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Заг сум/-	Алегротовер ХХК	1,767.7	1,767.7	225.3
15	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	Ганмөнхжин ХХК	1,746.7	1,746.7	397.1
16	Соёлын төвийн өргөтгөл, их засвар /Баянхонгор, Бөмбөгөр сум/	Эм Ти Эм Жи ХХК	314.5	314.5	314.5
	Өмнөх оноос шилжсэн ТАХ-ний санхүүжилтийн дүн		38,634.5	23,429.7	13,323.9
	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Баянхонгор, Баянхонгор, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Баянлиг, Жинст, Заг сум/	Чоногол трейд ХХК	244.1	244.1	244.1
17	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Баянхонгор, Баянхонгор, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Баянлиг, Жинст, Заг сум/ /машин/	Си ай ти ХХК	325.2	325.2	325.2
	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /Баянхонгор, Баянхонгор, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Баянлиг, Жинст, Заг сум/- PIMIS21013012	Медикал ресурс ХХК	177.8	177.8	177.8
18	Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн дээврийн засвар /Баянхонгор сум/	Буян Аривжих ОД ХХК	69.4	69.4	69.4
19	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	Алегротовер констракшн ХХК	4,957.0	1,500.0	1,500.0
20	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	Бридж бюлдинг ХХК	4,926.9	1,500.0	1,500.0
21	"Цэвэр хот" төсөл хэрэгжүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум/- Шинэ суурьшлын бүсийн гадна цэвэр усан хангамж, бохир усны шугамын ажлын материал нийлүүлэх	Базардарь ХХК	995.0	988.9	988.9
	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/- Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний машин 1ш, Тусгай зориулалтын шүршигч машин 4ш, Явуулын тусгай зориулалтын лаборатори 1ш	Бат билэг гурван эрдэнэ ХХК	350.6	350.6	350.6
22	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/- МЭГазарт Малын шимэгчтэх өвчнийг оношлох лабораторын тоног төхөөрөмж нийлүүлэх	СИНАПС ХХК	345.0	345.0	345.0
	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/- МЭГазарт Мал угаалгын ванн	Жаргантайн хөх тариа ХХК	145.6	145.6	145.6
	Малын паразит болон бусад өвчлөлөөс сэргийлэх угаалга, ариутгалын зориулалттай автомашин, зөөврийн тоног төхөөрөмж /Баянхонгор/- Мал эмнэлгийн лабораторийн тусгай зориулалтын эд хогшил	АЙЕТИ ЮНИПИКЭШН ХХК	28.6	28.6	28.6
	Жижиг, дунд, бичил үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр-Явган замын хавтан үйлдвэрлэлийн иж бүрэн автомат тоног төхөөрөмж	Буянт хөрс наран ХХК	125.0	125.0	125.0
23	Жижиг, дунд, бичил үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр-Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-Т ЖДҮ-ийн тэвштэй автокран, бага оврын трактор	Буянт хөрс наран ХХК	167.5	167.5	167.5
	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/- ингэний сүүний үйлдвэрийн барилгын ажил	Базардарь ХХК	3,848.1	400.0	400.0
24	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ мах, хүнсний ногооны 1000 тн агуулахын барилга	САНТ-ӨНДӨР ХХК	3,074.9	250.0	250.0

	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Шинэ суурьшлын бүсийн гадна холбооны шугам материал нийлүүлэх захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ	НЬЮ БЕСТ ХАУС ХХК	808.2	250.0	250.0
	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ Цахилгааны эх үүсвэрийн ажил гүйцэтгэх, материал нийлүүлэх	ЭН ДИ ЭМ ЭМ ХХК	1,195.0	400.0	400.0
	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ цэвэрлэх байгууламж- Шинэ суурьшлын бүсэд цэвэрлэх байгууламж ТОПАЭРО төхөөрөмж	АЛТАЙ ЭКОЛОС ХХК	735.0	200.0	200.0
25	Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын цэцэрлэгийн засвар-	Базардарь ХХК	70.5	70.5	70.5
26	Баянхонгор аймгийн цөлжилт, газрын доройтолд өртсөн газарт хамгаалалтын зурвас байгуулах	Би Эйч Энд Ди ХХК	99.9	-	-
27	Баянхонгор аймгийн Цагаан агуй орчмын аялал жуулчлалыг жимийг тохижуулах	Шинэ санаа ХХК	29.8	-	-
28	Цэцэрлэгийн барилгын дээврийн их засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/	Гялгар хайрхан ХХК	98.3	-	-
12	ШИНЭ АЖЛЫН ДҮН		22,817.4	7,538.2	7,538.2
28	Нийт санхүүжигдэх дүн		61,451.9	30,967.9	20,862.1

Аудитын илрүүлэлт

- Баацагаан сумын "Нутгийн удирдлагын ордон"-ы гүйцэтгэгч "Бианконэро констракшн" ХХК нь ажлаа бүрэн гүйцэтгээгүй байхад Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2021.12.12-ны 2021/75 тоот дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан акт үйлдэж, санхүүжилтийг 100% олгосон.

- Заг сумын 160 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч "Энх баялаг констракшн" ХХК нь гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг баталгаажуулан 328.0 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан байхад ажлын тоо хэмжээг хянаагүй илүү санхүүжилт олгосон байна.

- Галуут сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийн гүйцэтгэгч "Алегротовер констракшн" ХХК нь гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг баталгаажуулан 448.6 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан байхад ажлын тоо хэмжээг хянаагүй илүү санхүүжилт олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам 9.4²-т заасан заалтыг зөрчсөн байна

Иймд дээрх Баацагаан сумын "Нутгийн удирдлагын ордон"-ны барилгын ажлыг дуусаагүй байхад байнгын ашиглалтад авч, шийдвэр гаргаж, комиссын актад гарын үсэг зурж баталгаажуулсан, илүү ажлын санхүүжилт олгосон холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцож, гүйцэтгэгчээр дутуу хийсэн 1,161.3 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.3.3. Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс эрх шилжсэн болон шилжээгүй төсөл арга хэмжээнүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ХБТХОХ-ээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны 6р сараас 11 сарыг хүртэлх хугацаанд 17 удаагийн хяналт шалгалтыг хийж, барилга,

² Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл болон төсвийн дагуу норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга, угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна

угсралтын ажлын чанар, аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах талаар барилга угсралтын ажлын журналд бүртгэж үүрэг даалгавар өгч ажилласан байна. Мөн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авч ажиллах тухай мэдэгдэх хуудас, ашиглаж байгаа барилгын материалыг лабораторийн шинжилгээнд хамруулах мэдэгдэх хуудсыг 18 аж ахуйн нэгжид хүргүүлсэн байна.

Барилга угсралтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллах тухай албан бичгийг барилга угсралтын 25 компанид хүргүүлэн, зөрчлийг арилгуулж ажиллажээ.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг Сайдын багцаар нь үзвэл:

- БХБС-ын багцаас хэрэгжүүлж буй 3 төсөл арга хэмжээ
- БШУС-ын сайдын багцаас хэрэгжүүлж буй 11 төсөл арга хэмжээ
- ЭМС-ын багцаас хэрэгжүүлж буй 3 төсөл, арга хэмжээ
- Соёлын сайдын багцаас хэрэгжүүлж буй 4 төсөл арга хэмжээ
- Биеийн тамир спортын хорооны санхүүжилтээр хэрэгжиж буй 2 төсөл арга хэмжээний ажилд тус тус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Б.4. 2021 онд хэрэгжиж байнгын ашиглалтад авсан 20,748.7 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Б.4.1. Тайлант онд аймгийн ТЭЗ-ийн барьцаа дансанд 7 төсөл арга хэмжээний дуусаагүй ажлын 4,704.2 сая төгрөгийг төвлөрүүлэн байршуулсан байна.

Хүснэгт № 06 Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд санхүүжилт байршуулсан төсөл, арга хэмжээ /сая төг/

Д.Д	Тайлант оны Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Байршуулсан дүн	Үүнээс: Чанарын баталгаа	Дуусаагүй ажлын санхүүжилт
1	Сургуулийн барилга, 160 суудал /Баянбулаг сум/	92.1	92.1	-
2	Сургуулийн барилга, 320 суудал /Баянцагаан сум/	1,562.1	-	1,562.1
3	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, 2,7,9-р /	396.1	396.1	-
4	Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг	396.6	-	396.6
5	Сургуулийн барилга, 160 суудал /Гурванбулаг сум/	561.2	-	561.2
6	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/	192.9	-	192.9
7	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Овоо сум/	79.5	79.5	-
8	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баян-Өндөр сум/	22.7	22.7	-
9	Эрүүл мэндийн төвийн барилга /Хүрээмарал сум/-	109.8	-	109.8
10	Засаг даргын Тамгын газрын барилга /Баацагаан сум/	60.0	60.0	-
11	Усан бассейн, спорт цогцолборын барилга	1,881.6	-	1,881.6
12	Соёлын төвийн барилга, 240 суудал /Хүрээмарал сум/	87.3	87.3	-
13	Соёлын төвийн өргөтгөл, их засвар /Бөмбөгөр сум/	15.7	15.7	-
	ДҮН	5,457.6	753.5	4,704.2

Дээрх дуусаагүй ажлын санхүүжилт байршуулсан төсөл, арга хэмжээнүүд нь өмнөх оноос шилжиж ирсэн барилгын ажлууд бөгөөд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-аас Сангийн яам дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын судалгааг авч оны эцэст үлдэгдэл санхүүжилтийн эрхийг аймгийн ТЭЗ-чид нээж өгснөөр дээрх 7 төсөл, арга хэмжээний 4,704.2 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

Б.4.2. Өмнөх онд захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Жинст сумын Соёлын төвийн барилгын 74.4 сая, Баянцагаан сумын сургуулийн барилгын 170.5 сая төгрөгийг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан бичгээр эрх нээлгэж, ажлын гүйцэтгэлээр гүйцэтгэгчид тус тус олгосон.

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дээрх 2 төсөл, арга хэмжээнээс Жинст сумын Соёлын төвийн барилгын ажлыг улсын комиссоор хүлээлгэн өгч ашиглаж эхэлсэн нь байршуулсан хөрөнгийн үр дүн гарч эхэлсэн байна.

Б.4.3. 2021 онд ашиглалтад орсон барилга, байгууламжаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр ирээгүй бөгөөд 2021 онд хэрэгжиж байнгын ашиглалтад авсан 65,059.0 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

Аудитын илрүүлэлт

Галуут, Бууцагаан сумын ЭМТ-д улсын төсвийн хөрөнгөөр хүлээлгэн өгсөн тус бүр 40.1 сая төгрөгийн Шүдний иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн боловч шүдний нарийн мэргэжлийн эмч байхгүйгээс 80.2 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна.

Иймд хөрөнгийг ашиглах боловсон хүчнийг сургах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ЭМГ-т зөвлөмжөөр хүргүүлэв.

Б.4.4. Баянхонгор аймагт эрх шилжин ирсэн нийт 64,738.3 сая төгрөгийн 28 ТАХ-ний төсөв батлагдсаны өмнөх онуудын төсвийн хуулиас авч дүн шинжилгээ хийв.

Аудитын илрүүлэлт

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээний 2,877.0 сая төгрөгийн төсөв нэмэгдэж 2022 оны Төсвийн тухай хуульд батлагдсан байна.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнээс тодруулахад:

- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн барилгыг анх 3200.0 сая төгрөгөөр 2020 онд батлагдсан бөгөөд тус барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг зураг төсөвт тусгаагаагүй байжээ. ТЭЗ-аас 2021 оны улсын төсвийн саналд 519.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал явуулсан боловч БШУЯ нь Барилгын хөгжлийн төвөөр нэмэлт төсвийг магадлуулахдаа гадна фасадыг өөрчлөн металл фасад болгож өөрчлөн анх батлагдсан төсвөөс 1,311.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,511.5 сая төгрөгөөр төсвийг баталгаажуулан 2022 оны төсөвт тусгагдсан байна.

- Гурванбулаг сумын 160 суудалтай 1,540.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий сургуулийн барилгын суурь өөрчлөгдсөн, анхнаасаа шугаман суурьтай нэг маягийн зургаар төлөвлөсөн байсныг

цэвдэгтэй газарт зураг өөрчлөх шаардлага үүсэж дахин зураг хийлгэж магадлалаар баталгаажуулахад 1,565.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,105.5 сая төгрөг болон нэмэгдсэн гэсэн тайлбар өгөв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдаж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүчин чадал, зураг, төсвийг хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөв батлагдахаас өмнө хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.4.5. Өмнөх оны улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитаар нийт 806.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 27.8 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 382.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 395.5 сая төгрөгийн 7 зөвлөмж, хүргүүлэн ажилласан байна.

Дээрх зөрчилд зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардлын 3.8 сая, магадлалгүй ажлын санхүүжилт 24.0 сая гүйцэтгэгчид илүү шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлсэн бол, санхүүжилт авсан атлаа ажлын гүйцэтгэл дутуу 220.7 сая төгрөгийн 2, УТХО-ын үр дүнд бий болсон хөрөнгө орлогод бүртгээгүй 162.1 сая төгрөгийн 1, баримт бичгийн бүрдэл хангаагүй 1 зөрчилд албан шаардлага өгч биелэлтийг хангуулсан байна.

Мөн арвилан хэмнэлт үр ашигтай холбоотой 395.5 сая төгрөгийн 3 зөвлөмж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 3 зөвлөмж, нийт 7 зөвлөмжийн биелэлтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 2/1805 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт № 07. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
Нэг. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа			
1	Төсвийн ерөнхийлөн захирагчдад зураг төсөв нь Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, иж бүрэн хийгдэж магадлалаар баталгаажуулсан төсөл арга хэмжээний саналыг хүргүүлж байх,	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Холбогдох яамдад магадлалаар оруулсан төсөв хүргүүлдэг боловч хасагддаг.
		Аудитаар тооцсон биелэлт	Тайлант онд хэрэгжих нийт зураг төсөв шаардлагатай 6 төсөл, арга хэмжээнээс 2 нь зураг төсөв баталгаажуулаагүй ажил байна. Биелэлт 66.7%
2	Барилга, байгууламжийн ашиглалтад хүлээн авах улсын комисс нь ажлыг хүлээж авахдаа магадлалаар баталгаажсан, зураг төсөвт тусгагдаагүй, эх үүсвэр шийдэгдээгүй нэмэлт ажил гүйцэтгэхийг шаардаж төсөвт хүндрэл учруулж байгааг зогсоох	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Цаашид нэмэлт гэрээ хийхгүй байх тал дээр анхаарч ажиллана.
		Аудитаар тооцсон биелэлт	Тайлант онд ашиглалтад хүлээн авсан 4 төсөл, арга хэмжээнд 424.3 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан нь зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Биелэлт 0%

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

3	Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээг батлагдсан нэрээр нь хэрэгжүүлж зорилтот түвшнийг хангаж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Цаашид анхаарч ажиллана.
		Аудитаар тооцсон биелэлт	Бүрэн хэрэгжсэн. Биелэлт 100%
4	Захиалагч, зохиогчийн хяналт хийсэн тайланг тухай бүр авч , гэрээг объект тус бүрээр дүгнэж, хэрэгжилтийг тооцож,төлбөр тооцоог хийж байх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Цаашид анхаарч ажиллана.
		Аудитаар тооцсон биелэлт	Бүрэн хэрэгжсэн. Биелэлт 100%
5	УТХО-аар хэрэгжүүлж 2020 онд ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн дутуу болон чанаргүй гүйцэтгэсэн ажилд Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	2021 оны 9 дүгээр сард аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ГХБХБГ, МХГ байгууллагууд хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан
		Аудитаар тооцсон биелэлт	Зөрчлийг арилгуулсан байна. Биелэлт 100%
6	Хүмүүнлэгийн ордны барилгын ашиглалтыг сайжруулах, төсвөөс хөрөнгө гаргахгүйгээр ашиглалтын зардлаа нөхөх хэмжээнд үйл ажиллагааг явуулах боломжийг судалж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн журам боловсруулж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Асуудлыг судалж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Зөвлөмж хэрэгжээгүй Биелэлт 0%
7	Баянговь сумын нутгийн удирдлагын ордон, Жинст сумын Соёлын төвийн гүйцэтгэгч нарт хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянаж дүгнэлт гарган баталгаажуулж барилгыг хүлээн авсан комиссын буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Цаашид улсын комиссын гишүүдэд хяналтыг сайжруулан, дутуу ажил хүлээж авах зөрчил гаргасан тохиолд хариуцлага тооцож болно.
		Аудитаар тооцсон биелэлт	Гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийг баталгаажуулан 1,161.3 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан байхад ажлын тоо хэмжээг хянаагүй илүү санхүүжилт олгосон байна.. Биелэлт 95%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 65.9%			

Б.5. Баянхонгор аймагт 2021 онд шинээр эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц шийдэгдэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хадгалалт, арилжааг дэмжсэн бодлого хэрэгжиж байна.

Б.5.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй дараах ажлын төсөл, арга хэмжээ нь аймгийн эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж урьчилан тооцоолсон байна. Тухайлбал:

1. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах 12,000.0 төгрөгийн төсөл арга хэмжээний хүрээнд баригдаж буй

Ингэний сүүний үйлдвэрт баригснаар:

- Үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадвал өдөрт 360 кг хуурай сүү боловсруулж зах зээлд нийлүүлнэ.
- Зөвхөн боловсруулах үйлдвэр 21 хүнийг байнгын ажлын байраар хангана

- Ингэний фермийг говийн чиглэлийн 13 сумд 4000 ингэний хагас эрчимжсэн аж ахуй байгуулах бөгөөд нийт 240 хүний байнгын ажлын байр, тодорхой тооны түр ажлын байр бий болно.
- Аймаг орон нутагт төвлөрөх татварын орлого нэмэгдэнэ.
- Баянхонгор аймгийн тэмээн сүргийн тоо толгой өсч, тааварлаг чанар нэмэгдэн, мал амьтны эрүүл бүсээ хамгаалах нөхцөл бүрдэнэ.
- Олон улсын (ISO) стандартад нийцсэн сүү хатаах цогц үйлдвэртэй болно.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж нэмүү өртөг шингээн гадаад орнууд руу экспортолно.

Мах, хүнсний ногооны 1000 тн агуулахын барилга баригдсанаар:

- Энэхүү төсөл бүрэн хэрэгжснээр Баянхонгор аймгийн малчид 1 жилд 3200 тн мах буюу хонин толгойд шилжүүлснээр дунджаар 160.000-180.000 хүртэл толгой малыг мах үнэд хүрэх цагаар зах зээлд борлуулж малчдын орлогыг 30-50% өсгөх боломжийг нээж өгч байгаа болно.
- Малчдын өөрсдийн санаачлага оролцоон дээр тулгуурласан нэгдлийг бий болгож, цаашид махны зах зээлд малчид өөрсдөө дундын ченжгүй оролцдог тогтолцоог бий болгох болно.
- Аймгийн хүнсний хангамжийг нэмэгдүүлж төмс, хүнсний ногоо хадгалах хөргөлттэй зоорины хангамжийг 50%-д хүргэж үнийн хэлбэлзэл багатай хүнсний ногоог хүн амын хэрэглээнд нийлүүлэх болно.

2. Жижиг, дунд, бичил үйлдвэрлэлийг дэмжих 300.0 сая төгрөгийн төсөл

Тухайн төслийн хүрээнд аймгийн Хот тохижилт ОНӨҮГ-ыг түшиглэн явган хүний замын хавтангийн үйлдвэрлэл бий болсноор:

- Баянхонгор аймгийн тоосжилтыг багасгах, хотын өнгө үзэмжийг сайжруулахад хувь нэмрээ оруулсан.
- Явган замыг хийх ажлыг тендер зарлаад өндөр өртөгтэй хийх, өндөр үнээр худалдаж авдаг байсан бол өөрсдөө үйлдвэрлэснээр эдийн засгийн хэмнэлт бий болсон

Б.5.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд аймгийн шинэ суурьшлын бүсэд 4.5 километр цэвэр усны хос шугам, 2.5 километр бохир усны шугам, 500 метр куб эзлэхүүнтэй цэвэр ус нөөцлөх эх үүсвэр бий болсон байна.

Мөн Галуут сумын төвийн шинэчлэл төсөл арга хэмжээний хүрээнд 2 километр авто зам, тус бүр 2 километр цэвэр ус, ариутгах татуурга, халаалтын шугам, замын камержуулалт, Эрдэнэцогт сумд 2.5 километр автозам, тус бүр 1.5 километр цэвэр ус, ариутгах татуурга, халаалтын шугам сүлжээний ажлын гүйцэтгэл хийгдэж байна.

Аудитаар нийт 7,780.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж мянган 1,261.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага өгч, 6,518.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймагт 2021 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь улсын болон орон нутгийн урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.
2. УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсөл, магадлал хийх тогтолцоо дүрэм, журмын дагуу хэрэгжиж байгаа ч зарим төсөл арга хэмжээний зураг төсвийг боловсруулаагүй байна.
3. Төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг дунд хугацааны бодлоготой уялдуулаагүйгээс гүйцэтгэж буй ажлын ачаалал харилцан адилгүй байна.
4. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлэхдээ журманд заасан хугацааг баримтлаагүй, эрх шилжүүлсэн шийдвэрийг аймгийн ТЕЗ-д хүргүүлэх явц удаашралтай байгаа нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй болох эрсдэлтэй байна.
5. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу жишиг баримт бичгийг үндэслэн, ХОХБТХ-ээс ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан боловч зураг төсөвгүй 2 ажилд тендер зарласан байна.
6. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны 2021 онд хийж дуусгах барилга угсралтын ажлыг бүрэн гүйцэтгүүлээгүй байна.
7. ГХБХБГ нь Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс хяналт тавих гэрээг байгуулаагүй байна.
8. 2021 онд хэрэгжиж байнгын ашиглалтад авсан 65,059.0 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.
9. Захиалагчийн зүгээс гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нартай хариуцлага тооцоогүй, тэдний хүсэлтээр гэрээг олон дахин сунгаж хэрэгжилтийг хангуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахгүй байгаагаас ажил удааширч төсөвт өртөг нэмэгдэх, төсөл арга хэмжээний эдийн засгийн үр өгөөж буурах зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна.
10. Баянхонгор аймагт 2021 онд шинээр эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц шийдэгдэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, хадгалалт, арилжааг дэмжсэн бодлого хэрэгжиж байна.

-оОо-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г эрэмбэлэн ангилж, холбогдох яамдад хүргүүлэхдээ эрхлэх асуудлын хүрээнд жагсаалтыг зөв ангилж холбогдох яамдад хүргүүлж байх.
2. Төсөл, арга хэмжээний зураг, төслийг хийлгэхдээ БХБС-ын 2020.6.14-ний 108 тоот тушаалаар баталсан Барилгын зураг, төсөв зохиох жишиг үнийг баримтлан зураг төслийн гэрээг хийж байх.
3. Батлагдсан зураг, төсөвгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх.
4. Засгийн газрын 2017.06.14-ны “Дүрэм батлах тухай” 170 дугаар тогтоолд 2018 оны 316 дугаар тогтоолоор орсон нэмэлт өөрчлөлтөөр дүрмийн 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтыг хэрэгжүүлж, ажил хариуцсан агентлагтай гэрээ байгуулж ажиллах.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлагдаж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүчин чадал, зураг, төсвийг хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөв батлагдахаас өмнө хүргүүлж байх.
6. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны 2021 онд хийж дуусгах барилга угсралтын ажлыг бүрэн гүйцэтгүүлж, хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу хариуцлагын арга хэмжээ авч ажиллах.

ХОЁР. АЙМГИЙН ЗДТГ-ЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.НАРАНБАЯР ТАНАА:

7. Галуут, Бууцагаан сумын ЭМТ-д улсын төсвийн хөрөнгөөр хүлээлгэн шүдний иж бүрэн тоног төхөөрөмжийг ашиглах боловсон хүчнийг сургах арга хэмжээ авч ажиллах.

ГУРАВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА:

8. Зураг, төсөвгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хууль зөрчих эрсдэлээс урьдчилан сэргийлж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хууль, эрх зүйн арга зүйгээр хангаж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-

ҮАГ-ыгн Аудитын гуравдугаар газарт хүргүүлэх санал

1. ТЕЗ-аас ирүүлсэн хүчин чадлыг харгалзан үзэж, тооцоолсон зураг, төслийг үндэслэн хүчин чадлыг тодорхойлж, хуульд өргөн барьж байх зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх
2. Төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг дунд хугацааны хөтөлбөр, хуваарийн дагуу жигд тасралтгүй хуваарилан хуульд өргөн мэдүүлж байх зөвлөмжийг холбогдох яамдад зөвлөмжөөр хүргүүлэх.

-oOo-